



МОНГОЛ УЛСЫН  
БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙДЫН  
ТУШААЛ

2020 оны 11 сарын 03 өдөр

Дугаар A/255

Улаанбаатар хот

Журам, заавар батлах тухай


Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын батлан хамгаалах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.14 дэх заалт, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь заалт, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.6 дахь заалт, 24 дүгээр зүйлийн 7.1.11 дэх заалт, Батлан хамгаалахын сайдын зөвлөлийн 5 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Цэргийн эмч нарын комиссын ажиллах журам”-ыг нэгдүгээр, “Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнд эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, диспансерын идэвхтэй хяналт явуулах заавар”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хавсралтаар баталсан эрх зүйн баримт бичгүүдийг 2020 оны 11 дүгээр сарын 05-ны өдрөөс эхлэн Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штаб, Төрлийн цэргийн командлал, харьяа нэгтгэл, анги, байгууллагын эмнэлэг, Цэргийн төв эмнэлэгт мөрдүүлэхийг Батлан хамгаалах яам /хурандаа Д.Ганхуяг/, Зэвсэгт хүчний Жанжин штаб /хошууч генерал Д.Ганзориг/, Төрлийн цэргийн командлал /бригадын генерал Б.Амгаланбаатар, бригадын генерал О.Энхбаяр/-д тус тус хариуцуулсугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын 2015 оны А/167, 2003 оны 2021 дүгээр тушаалуудыг хүчингүй болгохыг Зэвсэгт хүчний Жанжин штаб /хошууч генерал Д.Ганзориг/-т даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /хурандаа Б.Эрхэмбаяр/-т үүрэг болгосугай.



Г.САЙХАНБАЯР

1320100588

Батлан хамгаалахын сайдын 2020 оны

11 дугаар сарын 03-ны өдрийн  
125 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

## ЦЭРГИЙН ЭМЧ НАРЫН КОМИССЫН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Цэргийн эмч нарын комисс (цаашид “комисс” гэх)-ын Зэвсэгт хүчний цэргийн алба хаагчийн эрүүл мэндийн байдлыг тодорхойлон, дүгнэлт гаргаж, шийдвэрлэхтэй холбоотой харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Комисс нь “Цэргийн албаны тухай”, “Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай”, “Эрүүл мэндийн тухай”, “Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай” Монгол Улсын хууль болон холбогдох хууль тогтоомж, Засгийн газрын 2017 оны 144 дүгээр тогтоолоор батлагдсан “Иргэнийг цэргийн жинхэнэ албанад эрүүл мэндээр тэнцүүлэх болон цэргийн алба хаагчийн эрүүл мэндийн байдлыг тодорхойлох журам”, тэдгээрт нийцүүлэн Батлан хамгаалахын сайд, Эрүүл мэндийн сайд, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын батлан гаргасан дүрэм, журам, заавар болон энэхүү журмыг баримтлан ажиллана.

1.3. Журмын 1 дүгээр хавсралтад заасан комиссын бүрэлдэхүүнийг Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар Цэргийн төв эмнэлгийн мэргэшсэн алба хаагчдаас томилон ажиллуулна.

Хоёр. Эрүүл мэндийн байдлыг тодорхойлж, дүгнэлт гаргах

2.1. Комисс нь “Иргэнийг цэргийн жинхэнэ албанад эрүүл мэндээр тэнцүүлэх болон цэргийн алба хаагчийн эрүүл мэндийн байдлыг тодорхойлох журам”-ын 1, 2, 3, 5 дугаар хавсралтыг баримтлан офицер, ахлагч, сонсогч /ҮБХИС-ийн мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн суралцагч/, цэргийн гэрээт болон хугацаат цэргийн алба хаагчийн эрүүл мэндийн байдлыг тодорхойлно.

2.2. Комисс нь дараах эрүүл мэндийн үзлэг, шинжилгээний дүн, холбогдох баримт бичгийг үндэслэн дүгнэлт гаргана:

2.2.1.цэргийн ангийн анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх тусгай эмнэлэг, тусгай эмнэлэг, нэгдсэн эмнэлэг, бүсийн оношилгоо, эмчилгээний төв, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, цэргийн төв эмнэлгийн үндсэн болон төрөлжсөн мэргэшлийн эмч нарын;

2.2.2.энэхүү журмын 2.1-д заасан цэргийн алба хаагчийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийн;

2.2.3.цэргийн алба хаагчийн цэргийн академи, их, дээд сургууль, коллеж, дамжаанд суралцах болон энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэхтэй холбоотой гаргасан эрүүл мэндийн үзлэгийн;

2.2.4.цэргийн гэрээт болон хугацаат цэргийн албанад татагдагч иргэний эрүүл мэндийн байдалд дүгнэлт гаргасан цэрэг татлагын товчооны болон Зэвсэгт хүчний цэрэг татлагын төв дамжингийн эмч нарын комиссын;

2.2.5.цэргийн жинхэнэ албанад эрүүл мэндээр тэнцэхгүй гэсэн дүгнэлтээр чөлөөлөгдсөн офицер, ахлагчийг цэргийн албанад эгүүлэн авах, иргэнийг цэргийн жинхэнэ албанад эрүүл мэндээр тэнцүүлсэн цэргийн эмнэлгийн комиссын.

2.3. Хариуцсан эмч нь тухайн цэргийн алба хаагчийн өвчний үндсэн оношийг үзлэг, шинжилгээгээр тодруулж, холбогдох тасгийн ахлах эмч, даргад танилцуулж, энэхүү журмын 2.2-д заасан шаардлагатай баримт бичгийг комисст хүргүүлнэ.

2.4. Комиссын нарийн бичгийн дарга баримт бичгийн бүрдлийг хянан, комиссын дарга, гишүүдэд танилцуулж, хурлаар хэлэлцүүлэх зөвшөөрөл авна.

2.5. Цэргийн төв эмнэлэгт өвчний оношийг бүрэн тогтоох боломжгүй тохиолдолд төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн үзлэг, шинжилгээнд хамруулж, зөвлөх зэрэгтэй холбогдох эмч нараас зөвлөгөө авч болно.

2.6. Комисс нь сард 4-өөс доошгүй удаа, шаардлагатай тохиолдолд хугацаа харгалзахгүй хуралдана.

2.7. Комисс санал хураалтаар дүгнэлт гаргах бөгөөд нийт гишүүдийн 70-аас дээш хувийн саналаар шийдвэрийг хүчин төгөлдөрт тооцно.

2.8. Комиссын нарийн бичгийн дарга хурлын тэмдэглэлийг хөтлөн, гишүүдээр гарын үсэг зуруулж, баталгаажуулан, албан хэрэг хөтлөлтийг хариуцна.

2.9. Орон нутаг дахь Зэвсэгт хүчний цэргийн нэгтгэл, ангийн цэргийн гэрээт болон хугацаат цэргийн алба хаагч халдварт болон цочмог өвчнөөр өвчилсөн, яаралтай, төлөвлөгөөт мэс засал хийлгэсэн тохиолдолд тухайн цэргийн алба хаагчийг биеэр байлцуулахгүйгээр нэгтгэл, ангийн захирагчийн албан бичгээр гаргасан хүсэлт, орон нутгийн бүсийн оношлогоо эмчилгээний төв эсвэл аймгийн нэгдсэн эмнэлгийн дүгнэлтийг комисст хүргүүлж, дүгнэлт гаргуулж болно.

2.10. Цэргийн алба хаагчийн тайван цагт цэргийн жинхэнэ албанд эрүүл мэндээр тэнцэхгүй талаарх дүгнэлтийг өвчний түүх, эмнэлгийн дэвтэр болон энэхүү журмын 2 дугаар хавсралтад, гадаад оронд эмчлүүлэх болон ажлын нөхцөлийг өөрчлөх, сувилуулах зэрэг шийдвэрийг энэхүү журмын 3 дугаар хавсралтад тус тус бичиж, цэргийн эмч нарын комиссын дарга, гишүүд болон хариуцсан эмч гарын үсгийг зуруулж баталгаажуулна.

2.11. Цэргийн эмч нарын комиссын магадлагааг офицер, ахлагч, сонсогч /ҮБХИС-ийн мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн суралцагч/-д 3 хувь, цэргийн гэрээт болон хугацаат цэргийн алба хаагчид 4 хувь үйлдэж, 1 дүгээр хувийг үндсэн материалд, 2 дугаар хувийг БХЯ-ны Төрийн захиргааны удирдлагын газарт эсхүл ЗХЖШ-ын Хүний нөөцийн хэлтэст, 3 дугаар хувийг тухайн цэргийн алба хаагчид, 4 дүгээр хувийг харьяа цэргийн штабт хүргүүлнэ.

2.12. Цэргийн жинхэнэ албанд эрүүл мэндээр тэнцэхгүй гэсэн магадлагаагаар чөлөөлөгдсөн офицер, ахлагчийг цэргийн албанд эгүүлэн авах захиргааны шийдвэрийн үндэслэл нь цэргийн эмч нарын комиссын дүгнэлт байна.

### *Гурав. Комиссын эрх, үүрэг*

#### *3.1. Комисс нь дараах эрхтэй:*

3.1.1.цэргийн алба хаагчийг цэргийн жинхэнэ албанд эрүүл мэндээр тэнцэх талаарх дүгнэлт гаргах;

3.1.2.шаардлагатай тохиолдолд цэргийн алба хаагчийг өвчний учир гадаад оношилгоо, эмчилгээ хийлгэх эсэх талаар шийдвэр гаргах;

3.1.3.цэргийн алба хаагчийн эрүүл мэндийн дүгнэлт гаргахад шаардлагатай зарим асуудлаар БХЯ, ЗХЖШ, Төрлийн цэргийн командлалын холбогдох нэгжид санал, хүсэлт гаргах;

3.1.4.цэргийн төв эмнэлэг, цэргийн ангийн анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх тусгай эмнэлгийн дарга (эмч) нарт мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх;

3.1.5.цэргийн алба хаагчийн эрүүл мэндийн байдалд гаргасан цэргийн эмнэлгийн комиссын дүгнэлттэй холбоотой санал гомдлыг хянан шийдвэрлэх;

3.1.6.өвчтөний оношийг тодруулах, эрүүл мэндийн үзлэг, шинжилгээний дүн, холбогдох баримт бичиг нь дүгнэлт гаргахад хангалтгүй гэж үзвэл баримт бичгийн бүрдүүлбэрийг хангуулах.

### 3.2. Комисс нь дараах үүрэгтэй:

3.2.1.холбогдох хууль, тогтоол, дүрэм, журам, тушаал, зааврыг чанд сахиж, хөндлөнгийн нөлөөллөөс ангид ажиллах;

3.2.2.төрийн албаны болон эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрмийг мөрдөж ажиллах;

3.2.3.мэргэжлийн үүргээ чанд биелүүлэх;

3.2.4.хувь хүний болон албаны нууцыг хадгалах;

3.2.5.өвчтөний талаарх хууль тогтоомжоор хориглосноос бусад мэдээллийг холбогдох байгууллага, албан тушаалтан, иргэнд үнэн зөв өгөх;

3.2.6.ашиг сонирхлын зөрчил гаргахгүй байх;

3.2.7.жилийн эцэст ажлаа дүгнэж, тайланг 12 дугаар сарын 01-ний дотор БХЯ-ны Төрийн захиргааны удирдлагын газар, ЗХЖШ-ын эрүүл мэндийн хангалтын асуудал хариуцсан нэгжид тус тус хүргүүлэх.

### Дөрөв. Бусад зүйл

4.1. Цэргийн эмч нарын комиссын үйл ажиллагааны талаар гаргасан өргөдөл, гомдлыг БХЯ-ны Төрийн захиргааны удирдлагын газар болон холбогдох байгууллагад хүргүүлж, хянан шийдвэрлүүлнэ.

4.2. Энэ журмыг зөрчсөн байгууллага, албан тушаалтан, иргэнд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

Батлан хамгаалахын сайдын 2020 оны

11... дугаар сарын 03-ны өдрийн

11.5 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

Цэргийн эмч нарын комиссын ажиллах  
журмын нэгдүгээр хавсралт

## ЦЭРГИЙН ЭМЧ НАРЫН КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

1. Комиссын дарга: Цэргийн төв эмнэлгийн эмнэлзүй эрхэлсэн орлогч дарга

2. Гишүүдэд:

- Мэс заслын эмнэлзүйн төвийн захирал;
- Гэмтлийн эмнэлзүйн төвийн захирал;
- Дотрын эмнэлзүйн төвийн захирал;
- Мэдрэлийн эмнэлзүйн төвийн захирал;
- Яаралтай тусlamж, мэдээгүйжүүлэг, эрчимт эмчилгээний эмнэлзүйн төвийн захирал;
- Эмчилгээ, үйлчилгээний чанарын хяналтын албаны дарга.

3. Нарийн бичгийн дарга: Статистик, даатгал, мэдээллийн албаны дарга

---оо---

Батлан хамгаалахын сайдын 2020 оны  
11 дугаар сарын 03-ны өдрийн  
11 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

Цэргийн эмч нарын комиссын ажиллах  
журмын хоёрдугаар хавсралт

ЦЭРГИЙН ЭМЧ НАРЫН КОМИССЫН МАГАДАЛГАА № ....  
/ Архивын № ... /

Өвчиний түүх №

... оны ... р сарын ... - ны өдөр

- |   |                |
|---|----------------|
| 1. Овог:                                  | Нэр:           |
| 2. Нас: Хүйс: эрэгтэй, эмэгтэй /зур/      | Ангийн дугаар: |
| 3. Цэргийн цол: Мэргэжил:                 | Албан тушаал:  |
| 4. Үндсэн захиргаа:                       |                |
| 5. Цэргийн албанд татагдсан Цэргийн штаб: |                |
| 6. Цэрэгт ирсэн он:                       |                |
| 7. Үндсэн онош:                           |                |
| 8. Дагалдах онош:                         |                |

Тусгай тайлбар:

Уг өвчинөөр: цэргийн алба хаах хугацаанд анх өвчилсөн, үгүй /зур/

9. Эрүүл мэндээр чөлөөлөх өвчин, эмгэгийн онцлог, шинжилгээ:

10. ШИЙДВЭР: Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 144 дүгээр тогтоолын ..... дугаар хавсралтын ..... -р заалтыг үндэслэн уг өвчиний учир “Цэргийн жинхэнэ албанд эрүүл мэндээр тэнцэхгүй” гэж шийдвэрлэв.

Комиссын дарга: Цол, нэр, гарын үсгийн тайлал:

..... /...../

Гишүүд:

Цол: ..... /...../  
Цол: ..... /...../

Нарийн бичгийн дарга: Цол: ..... /...../

Хариуцсан эмч: Цол: ..... /...../

Батлан хамгаалахын сайдын 2020 оны  
11 дугаар сарын 03-ны өдрийн  
12 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

Цэргийн эмч нарын комиссын ажиллах  
журмын гуравдугаар хавсралт

ЦЭРГИЙН ЭМЧ НАРЫН КОМИССЫН ШИЙДВЭР  
/ Архивын № ... /

Улаанбаатар

№ .... ... оны ... р сарын ... - ны өдөр

Овог нэр:

Нас, хүйс:

Регистрийн дугаар:

Ажлын газар:

Албан тушаал:

Цол:

Хаяг:

Өвчний түүх:

Бодит үзлэг, шинжилгээ:

Онош:

Дагалдах онош:

Шийдвэр:

Комиссын дарга: Цол: ..... / ..... /  
Гишүүд:

Цол: ..... / ..... /  
Цол: ..... / ..... /

Нарийн бичгийн дарга: Цол: ..... / ..... /  
Хариуцсан эмч: Цол: ..... / ..... /

---оо---

Батлан хамгаалахын сайдын 2020 оны

11.. дугаар сарын 23-ны өдрийн  
дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

**ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ БИЕ БҮРЭЛДЭХҮҮНД ЭРҮҮЛ МЭНДИЙН  
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЗЛЭГ, ДИСПАНСЕРЫН ИДЭВХТЭЙ  
ХЯНАЛТ ЯВУУЛАХ ЗААВАР**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнд эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, диспансерын идэвхтэй хяналт явуулах заавар (цаашид "заавар" гэх)-ын зорилго нь зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнд эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээ хийж, эрүүл мэндийн зэрэглэл тогтоон, өвчлөлийг эрт илрүүлэх, шаардлагатай бүрэлдэхүүнийг диспансерын идэвхтэй хяналтад авах, эрүүлжүүлэх арга хэмжээг зохион байгуулж, хэрэгжүүлэхэд оршино.

1.2. Зааврыг Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллагын удирдлага, офицер, ахлагч, ажилтан алба хаагч нар, Цэргийн төв эмнэлэг (ЦТЭ) болон нэгтгэл, анги, байгууллагын анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх тусгай эмнэлэг (цаашид "ангийн эмнэлэг" гэх) -ийн эмч, эрүүл мэндийн ажилтан дагаж мөрдөнө.

1.3. Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний эрүүл мэндийн байдалд үзлэг хийх, дүгнэлт гаргах, эрүүл мэндийн байдлыг хянахад "Цэргийн албаны тухай", "Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай", "Эрүүл мэндийн тухай", "Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай" Монгол Улсын хууль болон холбогдох хууль тогтоомж, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 144 дүгээр тогтоолоор батлагдсан "Иргэнийг цэргийн жинхэнэ албанд эрүүл мэндээр тэнцүүлэх болон цэргийн алба хаагчийн эрүүл мэндийн байдлыг тодорхойлох журам", тэдгээрт нийцүүлэн Батлан хамгаалахын сайд, Эрүүл мэндийн сайд, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын болон Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн батлан гаргасан холбогдох эрх зүйн акт болон энэхүү зааврыг баримтлан ажиллана.

1.4. Батлан хамгаалах салбараас цэргийн тэтгэвэрт гарсан ахмад настныг эрүүл мэндийн урьдчилсан сэргийлэх үзлэгт Цэргийн төв эмнэлэг болон ангийн эмнэлгээс батлан гаргасан төлөвлөгөө, графикийн дагуу хамруулна.

1.5. Цэргийн төв эмнэлэгт цэргийн дээд цолтой болон батлан хамгаалахын тэргүүний ажилтан цол тэмдэгтэй ахмадуудад эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг дараалал харгалзахгүй үзүүлнэ.

1.6. Цэргийн алба хаагчийн гэр бүлийн гишүүд эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, диспансерын идэвхтэй хяналтад холбогдох хууль тогтоомжийн дагуу хамрагдаж болно.

Хоёр. Урьдчилан сэргийлэх үзлэгийн төрөл,  
эрүүл мэндийн зэрэглэл

2.1. Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг нь дараах төрөлтэй байна:

2.1.1.нэгтгэл, анги, байгууллагын Ангийн эмнэлгийн;

2.1.2.цэргийн төв эмнэлгийн Поликлиникийн;

2.1.3.энхийг дэмжих ажиллагаа, гадаад, дотоодын цэргийн академи, сургууль, дамжааны Сонгон шалгаруулалтын;

2.1.4.хэвтүүлэн эмчилж нарийн шинжилгээ хийх шаардлагатай зорилтот цэргийн алба хаагчийн Стационарны.

2.2. Цэргийн алба хаагчийн эрүүл мэндийн байдал нь дараах зэрэглэлтэй байна:

2.2.1.нэгдүгээр зэрэглэл /К-1/ – Эрүүл буюу эмчийн үзлэг, лабораторийн шинжилгээнд зарим үзүүлэлт нь хэвийн хэмжээнээс тодорхой хэмжээгээр өөрчлөгдсөн боловч цаашид өвчин нь даамжрах хандлагагүй, биеийн эрүүл мэнд нь хөдөлмөрийн чадварт нөлөөлөөгүй байдал;

2.2.2.хоёрдугаар зэрэглэл /К-2/ – Эмчийн ажиглалт, үзлэгээр эрүүл гэж үзэхээр боловч насын өөрчлөлт болон архаг өвчний илрэлтэй, эрхтэн системийн үйл ажиллагааны бага зэргийн өөрчлөлт нь хөдөлмөрийн чадварт нөлөөлөөгүй, поликлиникээр эмчлүүлэх, ээлжийн амралтыг нь эдлүүлэх, рашаан сувилалд сувилуулах шаардлагатай байдал;

2.2.3.гуравдугаар зэрэглэл /К-3/ – Насны өөрчлөлт болон амьдралын явцад олсон эрхтэн системийн үйл ажиллагааны алдагдалтай, архаг өвчин нь үе үе дахилт өгч, тэр нь хөдөлмөрийн чадварыг нь бууруулсны улмаас эмчийн хяналтад байнга байж, поликлиник, стационаараар эмчлүүлэх, богино хугацаагаар эмийн чөлөө авах, цаашид рашаан сувилалд зайлшгүй сувилуулах шаардлагатай байдал;

2.2.4.дөрөвдүгээр зэрэглэл /К-4/ – Архаг өвчний улмаас эрүүл мэнд нь мэдэгдэхүйц доройтож, хөдөлмөрийн чадвар нь эрс буурсан, хөдөлмөрийн нөхцөлийг нь хөнгөлөх, эсвэл тайван цагт цэргийн жинхэнэ албандаа эрүүл мэндээр тэнцэхгүй болсон байдал.

Гурав. Ангийн эмнэлгийн урьдчилан сэргийлэх үзлэгийг төлөвлөн явуулах

3.1. Ангийн эмнэлгийн дарга (эмч) нь эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх, хяналтын үзлэгийг жил бүр төлөвлөж, нэгтгэл, анги, байгууллагын захирагч (дарга)-аар батлуулан дараах байдлаар хэрэгжүүлнэ:

3.2.1.эрүүл мэндийн 1 дүгээр зэрэглэлд хамаарах офицер, ахлагч, ажилтан албан хаагч нарт жилд 2-оос доошгүй удаа;

3.2.2.эрүүл мэндийн 2 дугаар зэрэглэлд хамаарах болон хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажиллагсад жилд 4-өөс доошгүй удаа;

3.2.3.эрүүл мэндийн 3 дугаар зэрэглэлд хамаарах офицер, ахлагч, ажилтан албан хаагч нарт сард 1 удаа явуулж, хугацаат үзлэг, шинжилгээ, эмчилгээ, сувилгаанд хамрагдсан эсэхийг бүртгэн, эмчилгээ, оношилгооны үр дүнг тодотгож шаардлагатай арга хэмжээг авч ажиллана.

3.2.4.эрүүл мэндийн 4 дүгээр зэрэглэлд хамаарах офицер, ахлагчийг Цэргийн эмч нарын комиссын хурлаар хэлэлцүүлнэ.

3.2. Албан тушаалд шинээр томилогдсон офицер, ахлагч, ажилтан албан хаагчийг нэг сарын дотор үзлэг, шинжилгээнд хамруулж, бүртгэлд авна.

3.3. Ангийн эмнэлгийн дарга (эмч) нь тухайн жилд хийгдэх ЦТЭ-ийн Поликлиникийн эмч нарын урьдчилан сэргийлэх үзлэгийн товыг өмнөх оны 12 дугаар сарын 05-ны дотор гаргаж, үзлэгийн хуваарыг оруулж баталгаажуулна.

3.4. Үзлэгийг дараах байдлаар төлөвлөж, хэрэгжүүлнэ:

3.4.1.бие бүрэлдэхүүн жилд 1-ээс доошгүй удаа үзлэгт хамрагдсан байхаар;

3.4.2.эрүүл мэндийн 3, 4 дүгээр зэрэглэлд хамаарах офицер, ахлагч болон хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажиллагсад хуваарыг үзлэгийн өмнө

холбогдох гүнзгийрүүлсэн шинжилгээ, оношилгоог Цэргийн төв эмнэлэгт хийлгэсэн байхаар;

3.4.3.бие бүрэлдэхүүний нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд үндэслэн, үзлэг, шинжилгээнд Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлөөс баталсан журам, зааврын дагуу хамруулахаар.

3.5. Энэхүү зааврын 2.1.3-т заасан үзлэгт хамрагдах цэргийн алба хаагчид үндсэн мэргэжлийн эмчийн эрүүл мэндийн тодорхойлолт гарган баталгаажуулж, үзлэг эхлэхээс 7 хоногийн өмнө Цэргийн эмнэлгийн комисст хүргүүлнэ.

Дөрөв. Поликлиникийн эмч нарын эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийн бэлтгэлийг хангах

4.1. Зэвсэгт хүчний нэгтгэл, анги байгууллагын захирагч, дарга нь энэхүү зааврын 2.1.2-т заасан үзлэгт байнгын бие бүрэлдэхүүнийг бүрэн хамруулах асуудлыг хариуцаж, эмнэлгийн дарга (эмч) үзлэгийн өмнө дараах бэлтгэл ажлыг хангана:

4.1.1.үзлэг явуулах огноо, хамрагдах бүрэлдэхүүний жагсаалтыг үзлэг эхлэхээс 7 хоногийн өмнө Поликлиникийн даргад хүргүүлэх;

4.2.2.нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд үндэслэн тогтоосон товлолт үзлэг шинжилгээнд хамруулах бүрэлдэхүүний судалгаа, жагсаалтыг гарган, үзлэг эхлэхээс 14 хоногийн өмнө Поликлиникийн даргад хүргүүлэх;

4.2.3.шаардлагатай тохиолдолд цэргийн алба хаагчийг төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн үзлэг, шинжилгээнд хамруулж, оношиг баталгаажуулсан байх;

4.2.4.хүн нэг бүрийн биеийн жин, өндөр, цээж, хэвллийн эргэн тойрны хэмжээг үзсэн байна.

4.3. Поликлиникийн дарга үзлэгийн өмнө дараах бэлтгэл ажлыг хангана:

4.3.1.үзлэгт хамрагдах бүрэлдэхүүний нэр, регистрийн дугаарыг цахим бүртгэлд бүртгэж, үзлэгийн хуудас, лабораторийн шинжилгээний маягтыг бэлтгэх;

4.3.2.үзлэгийн үед заавар, зөвлөгөө өгөх, шинжилгээний хариу олгох, бүртгэл хөтлөх зэрэг дэмжлэг үзүүлэх сувилагч, зарим шаардлагатай эрүүл мэндийн ажилтныг нэмж ажиллуулах;

4.3.3.үзлэг, шинжилгээнд шаардлагатай аппарат, тоног төхөөрөмжийн үйл ажиллагааг шалгаж, бэлэн байдлыг нь ханган, хэрэгцээт урвалж, оношлуур, дагалдах хэрэгслийг хангалттай тоогоор бэлтгэх;

4.3.4.шаардлагатай бол хөнгөн өвчтэй иргэн, цэргийн алба хаагчдад үзүүлэх поликлиникийн үйлчилгээг түр хугацаагаар хязгаарлах;

4.3.5.үзлэгт хамрагдах бүрэлдэхүүнийг кабинетуудад хуваарилах ажлыг тухайн ангийн эмнэлгийн эмч, сувилагч (багийн ахлагч), хөтөч сувилагчаар гүйцэтгүүлэх.

4.4. Үзлэгт хамрагдах бие бүрэлдэхүүн дараах зүйлийг бүрдүүлж, бэлтгэл хангана:

4.4.1.иргэний үнэмлэх;

4.4.2.эрүүл мэндийн дэвтэр /карт, нисгэгчийн эрүүл мэндийн гэрчилгээ/;

4.4.3.вакцины дэвтэр;

4.4.4.цээж зураг /3x4/ нэг хувь;

4.4.5.хуурай, нойтон салфетка;

4.4.6.үзлэгт хамрагдахын өмнөх өдөр 21 цагаас хойш хоол хүнс, эм, тариа хэрэглэхгүй байх;

4.4.7.үзлэгт хамрагдах өдрөөс өмнөх 3 хоногт хоног архи, согтууруулах ундаа хэрэглээгүй байх;

4.4.8.үзлэг эхлэх өдрийн 08.00 цагт 200-300 мл зориулалтын саванд хийсэн шээсний шинжилгээний сорьцтой, өлөн ирсэн байх.

Тав. Поликлиникийн эмч нарын эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг явуулах

5.1. Поликлиникийн эмч нарын эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийг цэргийн төв эмнэлгийн байранд болон тухайн цэргийн нэгтгэл, анги, байгууллагын байнгын байрлалд хөдөлгөөнт хэлбэрээр явуулна.

5.2. Үзлэг явуулах цэргийн эмнэлгийн комиссыг дарга, дотор, мэс засал, гэмтэл, сэтгэц, мэдрэл, арьс харшил, халдварт, сурьеэ, нүд, чих хамар хоолой, шүдний эмч, эмэгтэйчүүдийн төрөлжсөн мэргэшлийн эмч нарын бүрэлдэхүүнтэйгээр ЦТЭ-ийн даргын тушаалаар томилж ажиллуулна.

5.3. Шаардлагатай тохиолдолд ангийн эмнэлгийн дарга (эмч)-ын хүсэлтээр бусад төрөлжсөн мэргэшлийн эмчийг томилон ажиллуулж болно.

5.4. Цэргийн эмнэлгийн комиссын дарга тухайн алба хаагчийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээний дүгнэлтийг үндэслэн энэхүү зааврын 2.2-т заасны дагуу эрүүл мэндийн зэрэглэл тогтооно.

5.5. Ангийн эмнэлгийн дарга /эмч/ тогтоосон хугацаанд үзлэгт хамрагдаагүй цэргийн алба хаагчийг тухайн жилд багтааж үзлэгт хамруулан, эрүүл мэндийн зэрэглэлийг тогтоолгож, диспансерын асуудлыг шийдвэрлэнэ.

5.6. Үзлэгээр дараах оношилгоо, шинжилгээг бүх бие бүрэлдэхүүнд заавал хийнэ:

5.6.1.флюорограмм /цээжний зураг авах/;

5.6.2.цус, шээсний ерөнхий шинжилгээ /эмчийн заалтаар дэлгэрэнгүй шинжилгээ/;

5.6.3.хэвлэлийн хэт авиан /ЭХО/ шинжилгээ;

5.6.4.зүрхний цахилгаан бичлэг;

5.6.5.цусны биохимиийн шинжилгээнд элэг, бөөрний үйл ажиллагаа, сахар, липид тодорхойлох /эмчийн заалтаар/;

5.6.6.ДОХ, тэмбүү, элэгний В, С вирусийн халдварт илрүүлэх хурдавчилсан оношлуур;

5.6.7.эмэгтэйчүүдийн эхо, хавдрын маркер тодорхойлох шинжилгээ /эмчийн заалт/;

5.6.8.амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэг;

5.6.9.уушгины багтаамж /эмчийн заалт/;

5.6.10.улаан хоолой, ходоод, нарийн гэдэсний дуран /эмчийн заалт/;

5.6.11.эмчийн заалтаар бусад шаардлагатай шинжилгээг нэмэлтээр хийнэ.

5.7. Нэмэлтээр 40-өөс дээш насны бүрэлдэхүүнд дараах оношилгоо, шинжилгээг хийнэ:

5.7.1.ходоод, улаан хоолойн дуран /жил бүр/;

5.7.2.нүдний даралт хэмжиж, нүдний угийг харах;

5.7.3.хавдрын маркерууд үзэх;

5.7.4.эмчийн заалтаар бусад шаардлагатай шинжилгээг нэмэлтээр хийнэ.

5.8. Энэхүү зааврын 5.6, 5.7-д зааснаас бусад өндөр нарийвчилсан оношилгоо, шинжилгээг хийлгэсэн тохиолдолд зардлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

5.9. Эрүүл мэндийн зэрэглэлийг дахин тогтоох болон оношийг нарийвчлан тодорхойлох зорилгоор хяналтын үзлэг, шинжилгээг хийж болно.

Зургаа. Стационарын төрөлжсөн мэргэшлийн урьдчилан сэргийлэх үзлэг явуулах

6.1. Стационарын төрөлжсөн мэргэшлийн урьдчилан сэргийлэх үзлэгийг хэвтэн эмчлүүлж буй цэргийн алба хаагчид нэн шаардлагатай эрүүл мэндийн нарийвчилсан оношилгоо шинжилгээг богино хугацаанд хийж, өвчнийг оношлох эмчлэх зорилгоор явуулна.

6.2. Поликлиникийн урьдчилан сэргийлэх үзлэгийн дүгнэлтийг үндэслэн шаардлагатай бүрэлдэхүүнийг хугацаа харгалзахгүй, бусад бүрэлдэхүүнийг 4 жилд нэг удаа стационарын төрөлжсөн мэргэшлийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан байхаар төлөвлөж ЦТЭ-ийн эмнэлзүй эрхэлсэн орлогч дарга, нэгтгэл, анги, байгууллагын захирагч /дарга/, эмнэлгийн дарга /эмч/ нар хамтран хэрэгжүүлнэ.

6.3. Тодорхой хугацаанд эмчийн хяналтад хийгддэг шинжилгээ /ангиографи, хэвлэй болон цээжний хөндийн биопси, бүх төрлийн мэдээгүйжүүлэгтэй хийгдэх шинжилгээ г.м.-г стационарын урьдчилан сэргийлэх үзлэгээр хийнэ.

6.4. Ангийн эмнэлгийн дарга (эмч) нар стационарын үзлэгт хамрагдах бүрэлдэхүүний нэр, регистрийн дугаар, судалгаа, үзлэгт хамрагдах хугацааг улирал бүрийн эхний долоо хоногт Цэргийн төв эмнэлгийн эмнэлзүй эрхэлсэн орлогч даргад албан бичгээр хүргүүлнэ.

6.5. Алба хаагч нь нэр, регистрийн дугаараа цахим бүртгэлд бүртгүүлж, стационарт хэвтэхээс өмнө шаардлагатай багажийн болон лабораторийн шинжилгээнд хамрагдсан байна.

6.6. Төлөвлөсөн хугацаанд үзлэгт хамрагдаагүй алба хаагчийг тухайн жилд багтааж үзлэгт заавал хамруулна.

6.7. Үзлэгт хамрагдах алба хаагчид дараах оношилгоо, шинжилгээг хийнэ:

6.7.1.цус, шээсний ерөнхий шинжилгээ;

6.7.2.биохимиийн шинжилгээ /элэг, бөөрний үйл ажиллагаа, сахарын 3 сарын дундаж, электролитууд, ИНЛП, БНЛП, триглицерид, холестерин, амилаза, шээсний хүчил/;

6.7.3.иммунологийн шинжилгээ, бамбайн даавар, ДОХ, тэмбүү, элэгний В, С вирусийн халдварт илрүүлэх

6.7.4.хавдрын маркер /элэг, нойр булчирхай, уушги, бүдүүн шулуун гэдэс/ тодорхойлох шинжилгээ

6.7.5.цээжний рентген зураг болон харалт /цээжний зураг авах/

6.7.6.хэвлэлийн хэт авиан /ЭХО/ шинжилгээ

6.7.7.зүрхний цахилгаан бичлэг

6.7.8.зүрхний хэт авиа

6.7.9.эмэгтэйчүүдийн эхо

6.8. Стационарын урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан алба хаагчид эмчийн заалтаар улаан хоолой, хodoодны уян дуран, бүдүүн шулуун гэдэсний дуран, уушгинь багтаамж үнэлэх шинжилгээ, улаан хоолойн зүрхний хэт авиа /TEE/, тархины цахилгаан бичлэг, тархины судасны допплер, компьютер томографи, MRI зэрэг өндөр нарийвчилсан шинжилгээг нэмэлтээр хийнэ.

6.9. Стационарын төрөлжсөн мэргэшлийн эмчийн үзлэгээр эрүүл мэндийн 3, 4 дүгээр зэрэглэлд хамаарах алба хаагчийг 6 сар тутамд стационарын давтан үзлэг, шинжилгээнд хамруулна.

## Долоо. Диспансерын идэвхтэй хяналт явуулах

7.1. Диспансерын идэвхтэй хяналт нь өвчтөнг хяналтад бүртгэх, ажиглах, шаардлагатай үзлэг, шинжилгээ хийх, зөвлөгөө өгч, эмчилгээ хийх замаар эрүүлжүүлэх цогц арга хэмжээ юм.

7.2. Ангийн эмнэлэг, ЦТЭ-ийн поликлиник нь диспансерын идэвхтэй хяналтыг явуулах үндсэн нэгж бөгөөд поликлиникийн төрөлжсөн мэргэшлийн эмч, ангийн эмнэлгийн дарга (эмч), нислэгийн эмч нар өвчтөнг диспансерын хяналтад авах, хяналтаас гаргах ажлыг хамтран зохион байгуулна.

7.3. Өвчтөнг дараах үзлэгээр илрүүлж, диспансерын идэвхтэй хяналтад авна:

7.3.1.алба хаагчийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулснаар;

7.3.2.эмнэлгийн тусlamж авсан алба хаагчид үзлэг, оношилгоо, шинжилгээ хийснээр;

7.3.3.тухайн жилд Цэргийн төв эмнэлэг болон иргэний эрүүл мэндийн байгууллагуудад хэвтэн эмчлүүлсэн цэргийн алба хаагчийн холбогдох баримт бичгийг үндэслэн;

7.3.4.шинэ болон сэргэж буй халдварт өвчинд өртөмтгий байдлыг үндэслэн хийгдсэн эрсдэлт бүлгийн харуулдан тандалтын үр дүн, тайлангийн үнэлгээг үндэслэн.

7.4. Диспансерын хяналтыг дараах байдлаар явуулна:

7.4.1.хяналтад авсан бүрэлдэхүүнийг эмчлэх, сувилах арга хэмжээг нэгтгэл, анги, байгууллагын захирагч /дарга/, ангийн эмнэлгийн дарга (эмч), нислэгийн эмч, ЦТЭ-ийн поликлиникийн даргатай хамтран төлөвлөж хэрэгжүүлнэ;

7.4.2.хяналтад авсан бүрэлдэхүүнийг ангийн эмнэлгийн дарга /эмч/ сар бүр, поликлиникийн төрөлжсөн мэргэшлийн эмч нар улиралд нэгээс доошгүй удаа үзлэг хийж, хяналт тавина;

7.4.3.хяналтад байгаа алба хаагч эмчилгээний заавар, дэглэмийн биелэлтэд ангийн эмнэлгийн дарга /их эмч, сувилагч/ хяналт тавина;

7.4.4.шаардлагатай үед ээлжийн амралтыг эдлүүлэх, сувилуулах ажлыг зохион байгуулна;

7.4.5.хяналтад байгаа алба хаагчид эрүүл мэндийн боловсрол олгоход дэмжлэг үзүүлэх, аливаа өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар заавар, зөвлөгөөг тогтмол өгнө.

7.5. Диспансерын идэвхтэй хяналтад дараах баримт бичгийг хөтлөнө:

7.5.1.диспансерын хяналтын карт /офицер, ахлагч, ажилтан албан хаагчийн эрүүл мэндийн дэвтэр/;

7.5.2.диспансерын хяналтын хуудас;

7.5.3.диспансерын хяналтын бүртгэлийн дэвтэр (цахим мэдээллийн сан).

7.6. ЦТЭ-ийн статистик, даатгал, мэдээллийн алба, ангийн эмнэлэг нь энэхүү зааврын 2.2-т заасан үзлэгийн дүн, эрүүл мэндийн зэрэглэлд судалгаа хийж, үр дунг тооцож ажиллана.

7.7. Хяналтын тайланг ЦТЭ-ийн дарга БХЯ-ны Төрийн захирагааны удирдлагын газарт, нэгтгэл, анги, байгууллагын эмнэлгийн дарга (эмч) нар ЗХЖШ-ын Эрүүл мэндийн хэлтэст жил бүрийн 12 дугаар сарын 25-ны дотор хүргүүлнэ.

7.8. Диспансерын хяналтын үр дүнг диспансерын идэвхтэй хяналтад орсон хүмүүсийн эрүүл мэндийн байдалд гарсан өөрчлөлтөөр дүгнэнэ. Тухайлбал, өвчтэй алба хаагч эрүүлжин К-3 зэрэглэлээс К-2 зэрэглэлд, К-2 зэрэглэлээс К-1 зэрэглэлд шилжсэн байх нь диспансерын хяналтын үр дүнг харуулах үзүүлэлт юм.

7.9. Эрүүл мэндийн байдлыг дүгнэхдээ:

7.9.1. Сайжирсан;

7.9.2. Өөрчлөлтгүй (хэвэндээ);

7.9.3. Хүндэрсэн гэсэн үзүүлэлтээр дүгнэнэ.

7.10. Диспансерын хяналтын үр дүнг тооцоходоо динамик үзүүлэлтийг 3-5 жилээр гаргаж үнэлнэ.

Жишээ нь: Өвчтөн “А”

Хяналтын жил	Өвчний сэдрэл	Хөдөлмөрийн чадвар түр алдалт		Тахир дутуугийн группд орсон	Нас барсан
		Тохиолдлын тоо	Өдрийн тоо		
1-р жил	5	3	100	-	-
2-р жил	4	4	80	-	-
3-р жил	1	1	20	-	-
4-р жил	-	-	-	-	-
5-р жил	-	-	-	-	-

Дүгнэлт: Өвчтөний эрүүл мэндийн байдал сайжирсан.

Өвчтөн “Б”

Хяналтын жил	Өвчний сэдрэл	Хөдөлмөрийн чадвар түр алдалт		Тахир дутуугийн группд орсон	Нас барсан
		Тохиолдлын тоо	Өдрийн тоо		
1-р жил	3	3	60		-
2-р жил	3	3	80		-
3-р жил	5	5	100		-
4-р жил	3	3	100		-
5-р жил	1	1	150	II группд	-

Дүгнэлт: Өвчтөний эрүүл мэндийн байдал хүндэрсэн.

7.11. Диспансерын үндсэн үзүүлэлт, үр дүнг доорх аргаар дүгнэж тооцоолно.

7.11.1. диспансерын хяналтын нэгдүгээр шатны ажлын үр дүнгийн үзүүлэлт:

7.11.1.1. диспансерын хяналтад авбал зохих хүмүүсийг хамарсан байдал:

*Жилийн дотор “Д” хяналтад шинээр авсан  
өвчтөний тоо*

Хамралт= \_\_\_\_\_ X 100

*Жилийн турш “Д” хяналтад авбал  
зохих өвчтөний тоо*

Диспансерын хяналтад авбал зохих хүмүүсийн бүлэгт:

- Энэ онд шинээр илэрсэн өвчтөний тоо;

- Үрьд онд илэрсэн боловч диспансерын хяналтад аваагүй байсан өвчтөний тоо;
- Эмчилгээний бусад байгууллагаас шилжин ирэгсэд орно.

7.11.1.2. өвчтөнг цаг алдалгүй илрүүлсэн байдал:

*Өвчний эхний үе шатанд илэрсэн  
өвчтөний тоо*

$$\text{Илрүүлэлт} = \frac{\text{тухайн онд илэрсэн бүх өвчтөний тоо}}{\text{X 100}}$$

7.11.2. диспансерын хяналтын хоёрдугаар шатны үр дүнгийн үзүүлэлт:

7.11.2.1. үзлэгийн төлөвлөгөөт хугацааны үзүүлэлт:

*Үзлэгийн төлөвлөгөөт хугацаандаа  
ирсэн “Д” хяналтын өвчтөн*

$$\text{Хугацааны үзүүлэлт} = \frac{\text{“Д” хяналтад байгаа нийт өвчтөн}}{\text{X 100}}$$

7.11.2.2. эмчлэн эрүүлжүүлэх ажлын хүрээний үзүүлэлт:

*Эмчлэн эрүүлжүүлэх арга хэмжээ  
авагдсан өвчтөн*

$$\text{Хүрээ} = \frac{\text{эмчилгээ, урьдчилан сэргийлэх арга  
хэмжээ шаардлагатай бүх өвчтөн}}{\text{X 100}}$$

7.11.2.3. диспансерын хяналтын идэвхт байдлын үзүүлэлт:

*Урьдчилан сэргийлэх үзлэгээр илрүүлж  
диспансерын хяналтад авсан хүний тоо*

$$\text{ДИ} = \frac{\text{Хяналтад байгаа нийт өвчтөн}}{\text{X 100}}$$

7.12. Диспансерын хяналтын үр дүнгийн үзүүлэлтийг дараах томьёогоор гаргана:

- ҮДҮ - Үр дүнгийн үзүүлэлт
- А – Доод бүлгээс дээд бүлэгт эрүүлжиж шилжсэн хүний тоо
- В – Дээд бүлгээс доод бүлэгт эрүүл мэнд нь муудаж шилжсэн хүний тоо
- П – Диспансерын хяналтад байгаа нийт өвчтөний тоо

$$\text{ҮДҮ} = \frac{A - B}{P} \times 100$$

7.13. дараах тохиолдолд диспансерын хяналтаас өвчтөнг гаргана:

7.14.1. бүрэн эрүүлжсэн бол;

7.14.2. шилжсэн тохиолдолд.

7.14. Диспансерын хяналтын чанар, үр дүнд ЦТЭ-ийн Поликлиник, ЗХЖШ-ын Эрүүл мэндийн хэлтэс, БХЯ-ны хяналт-шинжилгээ үнэлгээний асуудал хариуцсан нэгж хяналт тавина.

Найм. Диспансерын идэвхтэй хяналтад авах өвчин, эмгэгшлийн жагсаалт

№	Өвчний нэр	Өвчний код	Үзлэгт орох хугацаа
<b>Дотрын өвчинүүдийн диспансерын хяналтын журам</b>			
<b>Нэг. Цусны эргэлтийн тогтолцооны өвчин</b>			
<b>1.1.Цочмог хэрхт өвчин</b>			
1	Цочмог болон ужиг үений хэлбэрүүд	M05	Улиралд 1 удаа
2	Хэрхт чичрэгийн зүрхэнд орсон хэлбэрүүд	M79.0	Улиралд 1 удаа
<b>1.2.Зүрхний архаг хэрхт өвчин</b>			
3	Зүрхний хавхлагийн бүтэц буюу давхрааг хамарсан эмгэгүүд	I05-09	Улиралд 1 удаа
<b>1.3.Цусны дараалт ихсэх өвчин I –10</b>			
4	I-үе	I10	Улиралд 1 удаа
5	II-үе	I10	3 сард 1 удаа
6	Зүрхний хэм алдагдлын эмгэгүүд	I44-49	Улиралд 1 удаа
7	Зүрхний бах	I20	3 сард 1 удаа
8	Зүрхний булчингийн цочмог шигдээс	I21	Эхний 6 сард сар тутам
9	Зүрхний булчингийн архаг шигдээс	I25.2	Жилд 2 удаа
10	Халдварт, харшлын гаралтай миокардит	I40.0	3 сар тутам 1 удаа
11	Цусны дараалт багадалт	I95.0	Жилд 2 удаа
<b>Хоёр. Амьсгалын тогтолцооны өвчин</b>			
12	Уушгинь хатгаа	J13-15	Эхний жилд 2 удаа
13	Уушгинь архаг үрэвсэлт, бөглөрөлтөт өвчинүүд	J44	Жилд 2 удаа
14	Уушгинь гялтан хальсны үрэвсэл, түүний үлдэц	J90	Эхний жилд 2 удаа, цаашид жилд 1 удаа
15	Гуурсан хоолойн багтраа	J45	Сэдрэлт, өвчний үе шатаас хамаарч жилд 2-оос доошгүй
<b>Гурав. Хоол боловсруулах эрхтний өвчин</b>			
16	Ходоод, 12 хуруу гэдэсний шархлаа	K25	Улиралд 1 удаа
17	Ходоодны үрэвсэлт өвчинүүд	K29	Улиралд 1 удаа
18	Тогтонги явцтай элэгний архаг үрэвсэл	K72	Жилд 2 удаа
19	Идэвхтэй явцтай элэгний архаг үрэвсэл	K73	Улиралд 1 удаа
20	Вирусийн гаралтай элэгний хурц үрэвслүүд	B15-18	Эхний жилд 2 сард 1 удаа
21	Цөсний архаг үрэвсэл	K81	Жилд 2 удаа
22	Нойр булчирхайн архаг үрэвсэл	K85	Жилд 2 удаа
<b>Дөрөв. Бөөр, шээс ялгаруулах эрхтэн тогтолцооны өвчин</b>			
23	Бөөрний цочмог үрэвсэлт өвчин	N10	Эхний жилд улиралд 1 удаа
24	Архаг пиемонефрит	N11.0	Улиралд 1 удаа
<b>Тав. Дотоод шүүрэл, тэжээлийн ба бодисын солилцооны өвчин</b>			
25	Бамбай булчирхайн хордлогот өвчин	E05	Улиралд 1 удаа
26	Чихрийн шижин	E10-14	Улиралд 1 удаа
27	Подагра	B10	Жилд 2 удаа

28	Бамбай булчирхайн дутал	E03	Улиралд 1 удаа
<b>Зургаа.Мэс заслын өвчин</b>			
29	Ясны үрэвсэл /хүнд хэлбэр /	M89	2 сар тутам зураг авхуулж хянах
30	Ясны үрэвсэл /хөнгөн хэлбэр /	M89	Жилд 2 удаа
31	Ясны хугарал, үе мөчдийн гэмтлүүд	S52	2 сард 1 удаа
32	Тромбофлебит, облитрирующий эндоартрит	I80	45 хоногт нэг удаа
33	Доод мөчдийн венийн судасны өргөсөлт /өвдөлт, хямралгүй бол/	I83	Жилд 2 удаа
34	Ходоод тайрсан ба шархлааг өөлсөн, оёсон хагалгааны дараах байдал	K25	Сард 1 удаа
35	Элэгний хатуурал, хавдар, бэтэг	K74, C22	Сард 1 удаа
36	Улаан хоолой, ходоодны улайлт, шархлаа, ургацаг, хавдар	I85	14 хоног тутам үзүүлж, 2 сард 1 удаа шинжлүүлнэ
37	Хагалгааны дараах гэдэсний наалдаст өвчин, наалдаст түүжрэл /үйл ажиллагааны хямралтай/	K91.3	Сард 2 удаа
38	Хагалгааны дараах гэдэсний наалдаст өвчин, наалдаст түүжрэл /үйл ажиллагааны хямралгүй/	K31.5	2 сард 1 удаа
39	Бүдүүн, нарийн гэдэс тайрсан, залгасан хагалгааны дараах байдал	K63.8	Эхний үед 7 хоног тутам, цаашид сар тутам
40	Цэсний хүүдий, замын чулуужих өвчин	K80	Улиралд 1 удаа
41	Бөөр, шээсний замын чулуужих өвчин	N20	3 сард 2 удаа
42	Уушги, цээжний хөндийд хагалгаа хийлгэсний дараах байдал	S20	Эхний үед 14 хоног тутам, цаашид 2 сард 1 удаа
43	Тархины битүү гэмтлийн дараах улдэц, ужгууд	S00-09	2 сард 1 удаа
44	Нурууны нугалам ясны хугарал, шахагдалт, нугасны хөнгөн дарагдалт	S32	Сард 1 удаа
45	Гэмтлийн улмаас үүссэн мэдрэлийн ширхэгийн гэмтэл, саажилт, хундрэлүүд	S14.1	Сард 1 удаа
46	Парапроктит, шамбарам	K61	Сард 1 удаа
47	Түлэгдлүүд, тэжээлийн хямралт шархлаа	T20	45 хоногт 1 удаа
48	Шээсний сувний гэмтэл ба нарийсалт, түрүү булчирхай, давсгийн үрэвсэл	N35	Улиралд 1 удаа

49	Бүх төрлийн хавдрууд болон хавдрын урьдал өвчинүүд	C00-D48	Сард 1 удаа
<b>Долоо.Чих, хамар, хоолойн өвчин</b>			
50	Гадна чихний холестеатом	H60.4	Сард 1 удаа
51	Гадна чихний сувгийн олдмол нарийсал	H61.3	Улиралд 1 удаа
52	Дунд чихний архаг шүүдэст үрэвсэл	H65.2	Сард 1 удаа
53	Хэнгэрэг-сонголын гуурсны гаралтай дунд чихний архаг идээт үрэвсэл	H66.1	Сард 1 удаа
54	Адар гонхны гаралтай дунд чихний архаг идээт үрэвсэл	H66.2	Сард 2 удаа
55	Архаг мастоидит	H70.1	Сард 1 удаа
56	Дунд чихний холестеатом	H71	Сард 2 удаа
57	Дунд чихний наалдаст өвчин	H74.1	Сард 1 удаа
58	Дунд чихний ур	H74.4	Сард 1 удаа
59	Отосклероз	H80	Сард 1 удаа
60	Тэнцвэрийн үйл ажиллагааны хямрал	H81	Сард 1 удаа
61	Дотор чихний бусад өвчин	H83	Сард 1 удаа
62	Дуу дамжуулах ба хүлээн авах хэлбэрийн сонгол бууралт I – II зэрэг	H90	Улиралд 1 удаа
63	Дуу хүлээн авах хэлбэрийн хоёр талын сонсгол бууралт I – II зэрэг	H90.3	Сард 1 удаа
64	Өөр бүлэгт ангилаагүй, мэс ажилбарын дараах чих ба хөхлөг сэргэнгийн эмгэгүүд	H95	Сард 1 удаа
65	Вазомотор ба харшилт ринит	J30	Улиралд 1 удаа
66	Архаг ринит, назофарингит ба фарингит	J31	Улиралд 1 удаа
67	Архаг синусит	J32	Улиралд 1 удаа
68	Хамрын ур	J33	Улиралд 1 удаа
69	Гүйлсэн булчирхай ба аденоидын архаг өвчин	J35	Улиралд 1 удаа
70	Архаг ларингит ба ларинготрахеит	J37	Улиралд 1 удаа
71	Дууны хөвч ба төвөнхийн өвчин	J38	Сард 1 удаа
<b>Найм.Нүдний өвчин</b>			
72	Нүдний гэмтэл	S05	Жилд 2-3 удаа (гэмтлийн зэргээс хамаарна)
73	Зовхины халдварт бус үрэвсэл /Дерматит/	H01.1	Жилд 2 удаа
74	Нулимсны эрхтний эмгэг	H04	Жилд 2 удаа
75	Вирусийн гаралтай цочмог салсархаг идээт- коньюктивит	H10.0	7-14-21 хоногт цааш жилд 1 удаа
76	Вирус болон харшлын гаралтай архаг - коньюктивит	H10.4	Жилд 2-3 удаа

77	Налихын бусад эмгэг	H11	Жилд 1 удаа
78	Эвэрлэгийн шарх	H16.0	(Гэмтлийн зэргээс хамаарна)
79	Глаукомын урьдал үе буюу сэжигтэй уед	H40.0	Жилд 2 удаа
80	Нээлттэй өнцөгт тогтвортой глауком	H40.1	4 сар -1 жил
81	Нээлттэй өнцөгт тогтвортой глауком	H40.1	1-4 сар (өвчтөний хүндийн зэрэг, эрсдэлт хүчин зүйл, нөөц чадамжаас хамаарна)
82	Хаалттай өнцөгт тогтвортой глауком	H40.2	6 сар-1 жил
83	Хаалттай өнцөгт тогтвортой глауком	H40.2	1-4 сар (өвчтөний хүндийн зэрэг, эрсдэлт хүчин зүйл, нөөц чадамжаас хамаарна)
84	Глаукомын урьдал үе буюу сэжигтэй уед	H40.0	Жилд 2 удаа
85	Янз бүрийн шалтгаантай болор цайх өвчин	H25-H28	Улиралд 1 удаа
86	Рефракци ба аккомдацийн эмгэг	H52	Жилд 1-2 удаа
87	Харааны мэдрэл ба харааны замын эмгэг	H46	Жилд 2 удаа
88	Торлогийн хуурал ба язрал	H33	Улиралд 1 удаа
89	Торлогийн бусад эмгэг	H35	Жилд 2 удаа
90	Шар толбо ба арын туйлын сэнөрөл	H35.3	Жилд 2 удаа

#### Ес.Арьс ба харшлын өвчин

91	Грибовидный микоз, Лайллын хам шинж, Стивен Жонсоны хам шинж, Арьсны цэврүүтэлт, Улаан чонон яр, Склеродерми, Рехленхаузын өвчин, арьсны хавдрууд	L12.8,L12.9 L93,L94,L51. 2 L51.1 C44	Улиралд 1 удаа
92	Арьсны тархмал дахилтат архаг өвчин, намарс, хайрст үлдийн хүндрэл, мэдрэлийн гаралтай арьсны өвчин, зангилаат маажуур, Гертиформный дерматит Дюринга, Фотодерматоз	L20-30.9 L40.3,L40.9 L28,L28.2, L20,L56.0 L13	Эмчилгээний явцад сэдэрсэн бол 1-2 жил, эмчилгээний дараа үргэлжлүүлэн 2-3 жил
93	Арьсны сүрьеэ, дотор эрхтний тархмал кандидоз	A18	Эмчилгээний дараа 1-2 жил

#### Арав.Тэмбүүгийн клиник өөрчлөлтийн хяналт

94	Тэмбүүгийн шинэ тохиолдол	A51.0	Эмчилгээний хойш 2 сар тутам серологи шинжилгээ хийнэ. 2 жил хяналтад.
95	Тэмбүүгийн бусад хэлбэр	A52, A53	Улирал тутам. 2 жил хяналтад.

Арван нэг.Халдварт өвчин			
96	Балнад, иж балнад	A01	6 сар тутам шинжилгээ хийнэ. 2-6 жил хяналтад.
97	Гэдэсний халдвар /сальмонеллёз/	A02.0	3 сар хяналт
98	Цусан суулга	A03.0	3 сар хяналт
99	Сүрьеэ /шинэ мэдрэг/	A15.0	Эмчилгээ дуустал 2 сар тутам шинжилгээ хийнэ.
100	Сүрьеэ /олон эмийн дасалтай/	A15.0	Эмчилгээ дуустал сар бүр түүнээс хойш 1-2 жил.
101	Элэгний А вирусийн халдвар	B15.0	3-6 сар хяналтад
Арван хоёр.Эрүү, нүүрний эмгэг			
102	Архаг остеомиелит	M86.6	14 хоногт үзүүлж, 6 сар хяналтад байх
103	Буйл, тойрон эдийн архаг үрэвсэл /парадонтоз/	K05.4	Сард 1-3 удаа үзүүлж, 6 сар хяналтад байх Сард 1-2 удаа үзүүлж, 6 сар хянана.
104	Эрүү, чамархайн үений архаг үрэвсэл	S03.4	14, 21, 30 хоногт үзүүлж, 1-2 жил хянана.
105	Шүдний гаралтай хоншоорын хөндийн архаг үрэвсэл	J-32.0	Сард 1-3 удаа үзүүлж, 6 сар хяналтад байх 7, 14, 21, 30 хоногт үзүүлж, 1-2 жил хянана.
106	Эрүү, нүүр орчмын хавдар, хавдар төст өвчин	C41	Сард 1 удаа үзүүлж, 1 жил хяналтад байх
107	Гурамсан мэдрэлийн үрэвсэл, невралги	G50.0	Сард 1 удаа үзүүлж, 2 жил хяналтад байх
108	Шүлсний булчирхайн архаг үрэвсэл	K-11	Сард 1-2 удаа үзүүлж, 2 жил хяналтад байх
109	Тунгалгийн булчирхайн архаг үрэвсэл	I88.1	Сард 1-2 удаа үзүүлж, 2 жил хяналтад байх
110	Эрүү, нүүр орчмын ясны гэмтэл	S00.8	Сард 1-2 удаа үзүүлж, 6 сар хяналтад байх
111	Амны салстын үрэвсэл лейкоплак	K13.2	Сард 1 удаа үзүүлж, 1 жил хяналтад байх
112	Эрүү, нүүр орчмын өвөрмөц үрэвсэл, актинотуберкулёз, микоз	K10.2	Сард 1-4 удаа үзүүлж, 1 жил хяналтад байх
Арван гурав.Мэдрэлийн эрхтэн тогтолцооны өвчин			
13.1.Мэдрэлийн тогтолцооны үрэвсэлт өвчин			
113	Бактерт мэнэн	G00	Эмгэг өөрчлөлт, үлдэцгүй эдгэсэн тохиолдолд диспансерын хяналтад авч, эхний нэг жилд улиралд 1 удаа, цаашилбал хагас жилд 1 удаа үзлэгт оруулна. Дэглэм, хөдөлмөр зохицуулалтыг хянана.
114	Халдварт ба шимэгч өвчний үеийн мэнэн	G02	
115	Бусад шалтагт ба тодорхой бус мэнэн	G03	
116	Энцефалит, миелит, энцефаломиелит	G04	
117	Гавал доторх ба нурууны суваг доторх флебит, тромбофлебит	G08	

### 13.2. Экстрапирамид ба хөдөлгөөний эмгэг

118	Суурийн зангилааны бусад сөнөрөлт өвчин	G23	ЭПС-ийн хөнгөн эмгэгтэй үед хяналтад авч, хагас жилд 1 удаа үзлэгт оруулна.
-----	---	-----	---

### 13.3. Тархины судасны өвчний үеийн судасны шинж

119	Тархины цусан хангамжийн дутагдлын эхний илрэл	-	Жилд 2 удаа
120	Тархины цусан хангамжийн архаг дутагдал	I69	Тархины үйл ажиллагааны болон органик өөрчлөлт хөнгөн илрэлтэй бол хяналтад авч улиралд 1 удаа үзлэгт хамруулна.

### 13.4. Мэдрэл, мэдрэлийн ёзоор ба сүлжээний эмгэг

121	Гурамсан мэдрэлийн эмгэг	G50	Тэжээлийн болон үйл ажиллагааны алдагдлын хөнгөн илрэлтэй бол диспансерын хяналтад авч улиралд 1 удаа үзлэгт хамруулна.
122	Нүүрний мэдрэлийн эмгэг	G51	
123	Гавлын бусад мэдрэлийн эмгэг	G52	
124	Мэдрэл ёзоор ба сүлжээний эмгэг дарагдал	G55	
125	Дээд мөчний нэг мэдрэлийн эмгэг	G56	
126	Доод мөчний нэг мэдрэлийн эмгэг	G57	
127	Захын мэдрэлийн тогтолцооны олон мэдрэлийн эмгэг	G60-61	

### 13.5. Нуруу эмгэгшил

128	Нуруу бөгтийх ба хотойх	M40	Дахилт цөөнтэй, эмчилгээнд засрал авч, мэдрэлийн судал, ширхэгийн дарагдлын шинж тэмдэггүй бол хяналтад авч хагас жилд 1 удаа хянана.
129	Нуруу мурийх	M41	
130	Нугалмын эмгэг /Спондилопати/	M45-49	

### 13.6. Тархи, нугасны гэмтэл

131	Гавлын мэдрэлүүдийн гэмтэл	S04	Мөчдөд тэжээлийн ба үйл ажиллагааны алдагдал хөнгөн илэрсэн бол хяналтад авч, хагас жилд 1 удаа үзлэгт хамруулна.
132	Гавал доторх гэмтэл	S06	
133	Хүзүү хугарах	S12	
134	Хүзүүний нурууны нум ба мэдрэл гэмтэх	S14	
135	Сээр нурууны хугарал, мэдрэл гэмтэх	S22	
136	Бүсэлхий, зоо нурууны түвшин дэх хугарал, мэдрэл гэмтэх	S34	
137	Мөр, бугалгын түвшинд мэдрэл гэмтэх	S44	
138	Шууны мэдрэл гэмтэх	S54	
139	Бугуй, сарвууны мэдрэл гэмтэх	S64	
140	Шилбэний түвшний мэдрэл гэмтэх	S84	
141	Шагай, тавхайн мэдрэл гэмтэх	S94	